



ТРАНЗИТ ТЭЭВЭРТЭЙ ХОЛБООТОЙ ХҮНДРЭЛ БОЛОН МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

*Илтгэгч Д.Байгалмаа (Далайн тээврийн салбарын
шинжлэх ухааны магистр)*


АГУУЛГА

1. Далайд гарцгүй орнуудын дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө
2. Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал
3. Чингэлэг саатуулсантай холбоотой гарах төлбөр торгууль
4. Дамжин өнгөрөх эрх чөлөө
5. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх нь
6. Шийдвэрлэх арга замууд


1. ДАЛАЙД ГАРЦГҮЙ ОРНУУДЫН ДЭЛХИЙН ХУДАЛДААНД ЭЗЛЭХ ХУВЬ

2019 оны байдлаар далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын дэлхий нийт худалдаанд эзлэх хувь бага хэвээр буюу ойролцоогоор 1 хувийг эзэлж байгаа ба үндсэндээ боловсруулаагүй түүхий эд хэлбэрээр зах зээлд нийлүүлэгдэж байна.

(UNCTAD/DITC/COM/2019/1/Corr.1)



2. МОНГОЛ УЛСЫН ИНФЛЯЦИЙН ТҮВШИН



<https://tradingeconomics.com/mongolia/inflation-cpi>

3. МОНГОЛЫН ТЭЭВЭР ЗУУЧЛАГЧДАД НОГДУУЛЖ БУЙ ЧИНГЭЛЭГ СААТУУЛСАНТАЙ ХОЛБООТОЙ ТОРГУУЛЬ

ЧИНГЭЛГИЙН ТӨРӨЛ	ЧИНГЭЛЭГ СААТУУЛСАНТАЙ ХОЛБООТОЙ ТОРГУУЛЬ /Ам.доллар \$/					
	7 хоног хүртэл	14-өөс дээш хоног тутамд	21 хоногоос дээш өдөр тутам	21-60 хоногий н хооронд өдөр тутам	60 хоногоос хойш хоног тутамд төлөх дүн	120 хоногоос хойш өдөр тутамд
20' (TEU)		90	180	2 009	3 091	5 370
40' (FEU)		180	361	4 019	4 491	10 740
40' (FEU) HC		202	342	4 491	6 909	11 943

Тайлбар: Энэхүү торгууль төлбөр нь 2021 оны 6 сарын байдлаар буюу, цар тахлын нөхцөл байдлын үед мөрдөгдөж байсан тариф бөгөөд одоогийн байдлаар мөрдөгдөхгүй байгаа хэдий ч чингэлэг саатуулсан төлбөр тодорхой хэмжээнд эдийн засагт нөлөөлсөөр байна. Мэдээллийг Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооноос ирүүлсэн болно.

ДАЛАЙН ТЭЭВРИЙН ХҮЧИРХЭГ ГҮРНҮҮДИЙН ЧИНГЭЛЭГ УДААСНЫ ТОРГУУЛИЙГ БУУРУУЛАХАД АВСАН АРГА ХЭМЖЭЭ

- ▶ Энэтхэг Улсын Далайн тээврийн яамнаас 2020.03.29-ны өдөр тушаал гаргаж 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдрөөс 2020 оны 4 дүгээр сарын 14-ны өдрүүдэд импорт болон экспортын бараа бүтээгдэхүүнийг далайгаар тээвэрлэхэд гарсан чингэлэг удаасны торгуулийг ногдуулахгүй байх үүрэг өгсөн байна. Түүнчлэн чингэлэг удаасантай холбоотой төлбөрийг нөхөн ногдуулах, газрын түрээс, боомт дээрх ачаа бараа хадгалалтын төлбөр, далайн боомтын зогсоолд зангуу хаяж зогсох гэх мэт үйл ажиллагаанд зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү төлбөр нэхэмжлэхийг хориглосон байна.
- ▶ АНУ-ын Холбооны Далайн тээврийн хорооноос 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр 1984 оны “Далайн тээврийн хууль”-д тусгагдсан чингэлэг саатуулсантай холбоотой зүйл, заалтад нэмэлт тайлбар, журам оруулсан байна. Энэхүү журамд чингэлэг удаасантай холбоотой торгуулийг ямар тохиолдолд ногдуулж болох, хэрэв ногдуулсан бол энэ нь хэр үндэслэлтэй болохыг хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан үзэж шийдвэрлэх тухай зүйл заалтууд ажээ.
- ▶ <https://unctad.org/webflyer/contracts-carriage-goods-sea-and-multimodal-transport>

4. ОЛОН УЛСЫН КОНВЕНЦЫН ДАГУУ ОЛГОГДСОН ЭРХ, ҮҮРЭГ

- ДАМЖИН ӨНГӨРӨХ ЭРХ ЧӨЛӨӨ:
 - Convention and Statute on Freedom of Transit, 1921
 - НҮБ-ын Далайн эрх зүйн тухай конвенц, 1982
 - Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр.

5. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД 2030

✓ Ядуурлыг бууруулна.

✓ Хэн нэгнийг ардаа үлдээлгүй бүгд хамтдаа урагшлана.



ТХЗ-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ


Тогтвортой хөгжлийн зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд дэлхий даяараа бүхий л холбогдох талууд хэрхэн хамтран ажиллаж байгаагаас шалтгаалах бөгөөд үүнд:

- ❑ Засгийн газрууд
- ❑ Иргэний нийгмийн төлөөлөл
- ❑ Хувийн хэвшлийнхэн, болон
- ❑ НҮБ-ын системийн бүрэлдэхүүн хэсгүүд

(<https://sustainabledevelopment.un.org/focussdgs.html>)



10 Largest Container Shipping Companies 2022



- 1. MSC – Mediterranean Shipping Company
- 2. APM-Maersk
- 3. CMA-CGM
- 4. COSCO – China Ocean Shipping Company
- 5. Hapag-Lloyd
- 6. ONE – Ocean Network Express
- 7. Evergreen Line
- 8. Hyundai Merchant Marine
- 9. Yang Ming Marine Transport
- 10. Zim Integrated Shipping Services Ltd

<https://www.marineinsight.com/know-more/10-largest-container-shipping-companies-in-the-world/>

Тайлбар: Чингэлгийг далайгаар тээвэрлэдэг дэлхийн топ 10 компанийн жагсаалт

6. БОЛОМЖИТ ШИЙДЭЛ, ГАРГАЛГАА

1. Далайн тээврийн компаниуд далайд гарцгүй хөгжиж байгаа болон ядуу буурай орнуудын экспорт болон ипмортын бараа бүтээгдэхүүнд зориулан тодорхой тооны чингэлгийг тодорхой хугацаанд чөлөөтэй ашиглуулах квот өгөх замаар эдийн засагт шууд дэмжлэг үзүүлж болно.
2. Далайн гарц бүхий хөрш орнууд далайд гарцгүй орны тусгай хэрэгцээг бодолцон, нутаг дэвсгэрээр нь дамжуулан тээвэрлэх далайд гарцгүй орны экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг хилийн боомт хүртэл саадгүй тээвэрлэх хүчин чадлыг хангах дэд бүтцийг сайжруулахад илүү анхаарал хандуулан ажиллах.
3. Далайд гарцгүй орнуудад олон төрлийн конвенцийн дагуу олгогдсон “Дамжин өнгөрөх эрх чөлөө” зүйл заалтыг холбогдох Олон Улсын байгууллагуудаас эргэн харж эдгээр заалт үнэхээр далайд гарцгүй орнууд чөлөөтэй байдлаар дамжин өнгөрч, худалдааны урсгалыг саадгүй нэвтрүүлж чадаж байна уу гэдэг дээр анализ, дүгнэлт хийх хэрэгтэй гэж үзэж байна.



**Анхаарал хандуулсанд
баярлалаа!**